



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/70

Хэрлэн сум

Болзолт уралдаан зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, Сангийн сайдын 2012 оны 23.9 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, түймрийн тоо болон хохирлын хэмжээг бууруулах зорилгоор сумд, тосгодын дунд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болзолт уралдааныг зохион явуулсугай.

Хоёр. Болзолт уралдаан явуулах хугацаа, дүгнэх журмыг хавсралтаар баталсугай.

Гурав. Болзолт уралдааны шагналын санд шаардагдах 2500000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн гамшигтай тэмцэх зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Болзолт уралдаанд идэвхтэй оролцож ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулан, тайланг хугацаанд нь ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, болзолт уралдааныг чанартай зохион байгуулж 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дүгнэж танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга /Онцгой байдлын хурандаа Д.Батжаргал/, Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Мөнх-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 421



БОЛЗОЛТ УРАЛДААН ЯВУУЛАХ, ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Болзолт уралдаан явуулах хугацаа, хамрагдах сум.

2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 18 сум, 5 тосгоны дунд зохион байгуулж явуулна. Болзолт уралдааныг журмын дагуу нийт 100 оноогоор дүгнэнэ.

Хоёр. Хийгдэх ажил

1. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан, хийж гүйцэтгэсэн ажил
2. Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөлүүдтэй байгуулсан гэрээ, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлж зохион байгуулсан ажил
3. Түймэртэй тэмцэхэд шаардагдах нөөц бүрдүүлэлт
4. Онцгой байдлын газрын даргатай сумдын Засаг дарга нар ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах
5. Түймэр унтраах багаж хэрэгслийг бүрдүүлэх, нөхөн хангах, нэмэгдүүлэх талаар авсан арга хэмжээ
6. Гарсан түймрийг шуурхай унтраах ажлыг (сум орон нутагтаа) хэрхэн зохион байгуулсан байдал
7. Түймэр гарсан тохиолдолд хөрш зэргэлдээх улс, аймаг, сумын нутаг руу оруулалгүй шуурхай унтраах
8. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ тайлан, илтгэх хуудсыг тухай бүр холбогдох газарт хүргүүлж байх
9. Ой, хээрийн түймрийн экологийн хохирлыг үнэн зөв бодитой гаргасан байдал /түймэр гараагүй тохиолдолд хамаарахгүй/

Гурав. Дүгнэх журам

- Түймэр гарсан болон унтаасан байдал - / 50 оноо /

Түймэр гаргахгүй байх, гарсан тохиолдолд түймрийг хөрш зэргэлдээх сум аймаг, улсын нутаг руу оруулалгүй хохирол багатай, богино хугацаанд шуурхай унтраасан байна. Мөн түймрийн мэдээ, мэдээлэл, цагийн байдал, хохирлын талаархи акт баримтыг цаг хугацаанд нь үнэн зөвөөр гаргаж өгсөн байх шаардлагатай. (Түймэр гаргаагүй, урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулж ажилласан бол 50 оноо.

Түймрийг богино хугацаанд хохирол багатай шуурхай унтраасан бол 35 оноо.

Түймрийг хожимдож хугацаа алдаж унтраасан мэдээ мэдээлэл хангалтгүй ирүүлсэн бол 20 оноо.

Түймрийн голомтыг тархан дэлгэрүүлсэн, хугацаа алдсан, хохирол зардал ихтэй унтраасан, дахин цурамнаас алдаж хариуцлагагүй хандсан бол 10 оноо г.м)

-Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил - /25 оноо/

Тухайн жилийн сумын төсөвт ой хээрийн болон объектын гал түймэртэй тэмцэх зардлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байдал, Орон

нутагтаа ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж материалжуулсан байна. Урамшуулалт морин болон мотоцикльтэй эргүүлийг түймэр гарах магадлалтай газруудаар ажиллуулан айл өрхүүдэд сэрэмжлүүлэг хүргэж яриа таниулга хийсэн байдал, төлөвлөгөө, төсөв баталж хэрэгжүүлсэн эсэх, түймэр гарсан тохиолдолд түймэрт дайчлагдсан хүмүүсийн хоол, хүнс, шатахуун зэргийг дараа төлбөртэйгээр шууд олгож байх талаар байгууллага, аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ зэргийг харгалзан дүгнэнэ.

Урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээг материалжуулсан байдлаар тайланг хугацаанд нь ирүүлсэн байна.

- Түймэр унтраах бэлэн байдал - /25 оноо/

МУ-ын Шадар сайдын 2013 оны 7-р тушаалын дагуу сумын мэргэжлийн ангийн хүн хүч, машин техник бэлэн байдал, түймэр унтраах 1,2,3-р ээлжийн бүрэлдэхүүний томилгоожуулалт, түймэр унтраах багаж хэрэгслийн /үлээгч аппарат, ус шүршигч, цуравдагч, цохиур, тросон шүүр, хүрз, цахилгаан хөрөө, сүх, анхны тусламжийн иж бүрдэл гэх мэт/ зүйлийн бүрдэл, түүнийг өмнөх оноос нэмэгдүүлсэн байдал, чанар стандартыг хангасан байдлаар дүгнэнэ.

/Аймгийн Засаг даргын нэрэмжит "Бэлэн байдлын үзлэг"-т дүгнэгдсэн оноогоор хамаарагдах болно/

Болзолт уралдааны тайланг 2017 оны 06 сарын 15, 12-р сарын 15-ны дотор ОБГ-т ирүүлсэн байна. Тайланг хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд авсан онооноос "10" оноо хасаж дүгнэнэ.

Дүнг 2017 оны 12-р сарын 25-нд Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газрын хамтарсан ажлын хэсэг сумдаас ирүүлсэн тайлан, холбогдох баримт, материал, бэлэн байдлын үзлэгийн дүнг үндэслэн дүгнэж дүнг аймгийн Засаг даргад танилцуулж шагналыг гардуулна.

Дөрөв. Шагнал урамшил

Нэг дүгээр байр-1, өргөмжлөл, 1000000 төгрөг буюу /Үлээгч аппарат-4ш/
Хоёр дугаар байр-1, өргөмжлөл 750000 төгрөг буюу /Үлээгч аппарат-3ш/
Гурав дугаар байр -1, өргөмжлөл 500000 төгрөг буюу /Үлээгч аппарат-2ш/
Тусгай байр-1, өргөмжлөл 250000 төгрөг буюу /Үлээгч аппарат-1ш/ тус тус шагнаж урамшуулна.

Тав. Үр дүн

1. Сум орон нутгийн түймрийн тоо, хохирол урьд оны мөн үеийнхээс буурна
2. Сумдын түймрээс урьдчилан сэргийлэх ажлын чанар сайжирна
3. Түймэртэй тэмцэх хүн хүч, техник. багаж хэрэгслийн бэлэн байдал хангагдана.